БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАН

Байгууллагын нэр: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар

***Баталгаажуулсан:***

*Орхон аймгийн Засаг дарга* Б.ЗОРИГТБАЯР

*(гарын үсэг)* ..........................

*(огноо)*

***Нэгтгэж тайлагнасан:***

Нийгмийн даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.НАРМАНДАХ

2025-12-05

*(гарын үсэг)* ..........................

*(огноо)*

**ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН**
**2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах *(Алсын хараа 2050 - 3.1.5, 3.1.6, ЗГҮАХ-2.1.3.2, АЗДҮАХ-4.1.1.6)* | | | | | | | |
| 1.1.1. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Шаард-лагагүй | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд 19 шийдвэр 18 журам, 25 зөвлөмж, 7 аргачлал чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын Хамралт орлогын чиглэлээр НДЕГ-ын даргын 2025 оны Маягтын загвар шинэчлэн батлах тухай А/204, А/281 дүгээр тушаал, НДЕГ-ын 2025.11.19-ний өдрийн 04/3061 тоот албан бичгээр өгсөн Ажил эрчимжүүлэх тухай чиглэл, НДЕГ-ын даргын 2025 оны А/244 тушаалаар өгсөн "Итгэлцлийн аян зохион байгуулах тухай", А/197 тушаалаар өгсөн "Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын менежментийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг тус тус хангаан ажилласан.<br>Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой 2024.12.13-ны өдрийн 11/365 тоот чиглэл, 2025.06.02-ны өдрийн 04/1360 тоот зөвлөмжийн хэрэгжилтийг хангаан ажиллаж байна.<br>Мөн хяналт шалгалтын чиглэлээр 1 журам, 6 зөвлөмж, 5 үүрэг даалгавар, 2 албан даалгавар, 4 чиглэлийн ирсэн бөгөөд тухай бүр хэрэгжилтийг тайлагнаж, үр дүнг тооцож ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.2. | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | Шаард-лагагүй | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, дээд газарт хүргүүлсэн мэдээ, тайлангийн тоо | 2024 онд Энгийн СДДаатгуулагч – 1155<br>0-3 настай хүүхдээ асарч байгаа эх – 15<br>Малчин даатгуулагч – 127<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх - 131 хамруулж ажилласан байна. | Сайн дурын даатгуулагч (малчин)-ийн тоог өмнөх оноос 135 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | 2025 оны жилийн эцсийн өдрийн байдлаар сайн дурын даатгалд нийт 4290 даатгуулагч хамрагдсан байна. Үүнд:<br>- Энгийн сайн дурын даатгуулагч 3276<br>- Малчин даатгуулагч – 322<br>- Тэтгэмжийн даатгалын сангаас хариуцан төлж байгаа 0-3 хүртэлх настай хүүхдээ асарч байгаа эх – 398<br>- Улсын төсвөөс хариуцан төлж байгаа 0-3 хүртэлх настай хүүхдээ асарч байгаа эх – 324<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг эцэг, эх даатгуулагч – 152 тус тус даатгуулсан байна.<br><br>2024 онд 127 малчин сайн дурын даатгалд хамрагдаж байсан бол 2025 онд 322 малчин хамрагдаж байгаа нь өмнөх оноос 195-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | |
| 1.1.3. | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | Шаард-лагагүй | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагч ийн тоо | 2024 онд шинээр 202 аж ахуйн нэгж байгууллагыг бүртгэж нийгмийн даатгалд хамруулсан. Ажил олгогч-117 хамруулахаас 202 ААНБ-ын 626 даатгуулагчийг хамруулан төлөвлөгөөг 172 хувьтай биелүүлэн ажилласан байна. | Ажил олгогчийн тоог 220, даатгуулагчийн тоог 660 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр Татварын хэлтэс, Хүнс хөдөө аж ахуй газраас судалгаа мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж 2025 онд шинээр үүсгэн байгуулагдсан шинэ хоршооны судалгааг авч мэдээлэл түгээн ажилласан.<br>2025 онд 95 аж ахуй нэгж байгууллага хамруулж, даатгуулагчийн тоог 266-аар нэмэгдүүлэн ажилласан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах (Алсын хараа 2050 3.1.1, 3.1.2, *ЗГҮАХ-2.1.3.1, 2.1.3.7, 3.2.1.5, АЗДҮАХ-4.2.1.1, 4.3.1.1, 4.3.1.2)* | | | | | | | |
| 2.1.1. | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл | Нийгмийн даатгалын санд 2024 оны жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 172,462.5 сая төгрөг буюу 94.02 хувиар биелүүлж, 169,036.1 сая төгрөгийг төв санд төвлөрүүлсэн. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалын төлөвлөгөөг 221,274.6 сая төгрөгөөр 100.43 хувийн биелэлттэй зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын 253.6 тэрбум төгрөгийн төлөвлөгөөг 251.8 тэрбум буюу 99.31 хувийн биелэлттэй зарцуулсан.<br><br>Нийгмийн даатгалын санд 2025 жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 217.8 тэрбум төгрөгөөр төвлөрүүлэхээс 189.3 тэрбум буюу 86.5 хувиар биелүүлж, ажиллалаа. | |
| 2.1.2. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл | 2024 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардалд 1,566,7 сая төгрөг зарцуулж 25.0 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | 2025 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардалд 1,722.7 мянган төгрөг зарцуулахаас 1,602.5 мянган төгрөгийг зарцуулж 120.2 мянган төгрөгийг хэмнэж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.3. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх. | | Батлагдсан 218 800 365.4 төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана. | Нийгмийн даатгалын санд 2024 жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 172,462.5 мян төгрөгөөр буюу 94.02 хувиар биелүүлж, 169036.1 сая төгрөгийг төв санд төвлөрүүлсэн. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын санд 218.800.365.4 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын санд 2025 жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 218.8 тэрбум төгрөгөөр төвлөрүүлэхээс 189.3 тэрбум буюу 86.5 хувиар биелүүлж, ажилласан. | |
| 2.1.4. | ЭМДЕГ-аас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх. | | ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар 31,027.1 сая төгрөг төвлөрүүлж 94.3 хувийн биелэлттэй байна. | ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна. | “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай” хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг тусгаагүй ба Эрүүл мэндийн даатгалын газар өөрсдөө орлогоо бүрэн хариуцахаар өөрчлөлт хийгдсэн. | |
| 2.1.5. | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх. | | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна. | Нийгмийн даатгалын шимтгэлийн оны эхний өр, авлага 5,576,596.43 мян төгрөг байснаас 3,030,284.61 мян төгрөг буюу 54.34 хувь бууруулж ажилласан байна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас доошгүй буурсан байна. | 2025 онд нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагад ХНХСайдын А/199 -р журмыг хэрэгжүүлэн ажиллаж 740 аж ахуй нэгж байгууллагын 5,881,815.38 мян/ төгрөгийн шимтгэлийн өрөнд арга хэмжээ авч 553 байгууллагын 2,896,949.36 мян/төгрөгийг барагдуулан нийт өр, авлагыг 49.25 хувиар буруулан ажиллалаа.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Итгэлцлийн аян” ажлыг зохион байгуулах А/244 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах 414 ааnб –ын 6,647.872,8 мян төгрөгийн өр авлагаас<br>- 41 байгууллагатай гэрээ байгуулж 191,801.3 мян төгрөг, сая төгрөг<br>- 8 байгууллагатай гэрээ сунгаж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 252,780.04 мян төгрөг,<br>- 13 байгууллагын данс гүйлгээг түр зогсоож 132,509.36 мян төгрөг 175 байгууллагын хуримтлагдсан авлагаас 875,395.96 мян төг буюу нийт 1,452,486.75 мян төгрөг буюу аяны хүрээнд 21.8 хувь барагдуулан ажилласан байна.<br>Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэн Уулзалт:<br>- Нийт 109 байгууллагад зохион байгуулан 89 байгууллагын 2 660 541.1 мян төгрөгийг барагдуулан<br>Албан шаардлага:<br>- Нийт 159 байгууллагад хүргүүлснээс 22 байгууллагын – 176 257.85 мян төгрөг<br><br>Данс хаасан:<br>- Нийт 205 байгууллагын 8 235 941.76 мян төгрөгөөс 111 байгууллагын 837 456 737 мян төгрөг<br>Гэрээ:<br>- Нийт 86 байгууллагыг 1 109 877.68 мян төгрөгийн өр авлагаас байгуулж 47 байгууллагын 249 870. 74 мян төгрөг<br>Шүүхэд:<br>- Нийт 3 байгууллага шилжүүлж гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна.<br><br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын 8 тойргийн 13 байгууллагын 14 захирамжийн 855 067.32 мян төгрөгийн шимтгэлийн авлага, 330350 мян төгрөгийн алдангид барагдуулалтын явцыг хэлэлцэн 4 байгууллагын 41177.84 мян төгрөгийн авлага барагдуулан хамтран ажилласан байна. | |
| 2.1.6. | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг барагдуулах | | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог хийсэн. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, өглөггүй байна. | 2024 оны эцэст 254.5 сая төгрөгийн өглөгтэй байсан ба 2025 оны жилийн эцсээр 340.9 сая төгрөг болж өссөн байна. Өглөг өссөн шалтгаан нь 2024-2025 онд даатгуулагчийн төлсөн алдангийн тооцооллыг шинэ систем бүртгэж, тооцоо бодуулах үйлдэл хийхгүй байгаатай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өглөггүй гарсан байна. | | | холбоотой юм.<br>Өглөг бууруулах ажлын хүрээнд:<br>- 208 даатгуулагчдад илүү төлсөн 43.8 сая төгрөгийг олгосон.<br>- 2024 оноос өмнө хугацаанд өглөг үүсгэсэн 1200 даатгуулагчдын арилжааны банкин дахь дансыг авч газрын даргын зөвлөлийн хурлаар шийдүүлэн 42.0 сая төгрөгийн илүү төлөлтийг буцаан олгосон. | |
| 2.1.7. | Бусад өглөг, авлагыг барагдуулах | | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар баталгаажсан байна. | а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах.<br>б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах. | Нийгмийн даатгалын сангийн бусад авлага 2024 оны жилийн эцсийн байдлаар 166.4 сая төгрөг байсан бол 2025 оны жилийн эцэст 91.3 сая төгрөг болж буурсан байна.<br><br>Мөн өглөг оны эхэнд 54.8 сая төгрөг байсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 161 иргэн, хуулийн этгээдтэй холбоотой 86.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. ЭМД-ын сан ЭМЯаманд шилжсэнтэй холбоотойгоор 51 иргэний 1.7 сая төгрөгийг ЭМД-ын сан руу шилжүүлж тооцоо нийлсэн. | |
| 2.1.8. | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | Нийгмийн даатгалын санд 2024 жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 172,462.5 мян төгрөгөөр буюу 94.02 хувиар биелүүлж, 169036.1 сая төгрөгийг төв санд төвлөрүүлсэн. | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна. | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллаж Нийгмийн даатгалын санд 2025 жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 217.8 тэрбум төгрөгөөр буюу 86.5 хувиар биелүүлж, 189.3 тэрбум төгрөгийг төв санд төвлөрүүлсэн. | |
| | Нийгмийн даатгалын сангийн зардлыг | | Хууль тогтоомжий | Нийгмийн даатгалын | а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр | Тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардлын 253.6 тэрбум төгрөгийн төлөвлөгөөг 251.8 тэрбум | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.9. | батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | | н дагуу иргэд даатгуулагчдад 247,243,830.6 мян төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан. Тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлын тухайд 2024 оны байдлаар 220,318.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд 221,274.6 сая төгрөгийг зарцуулсан. | олгох<br>б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу 247,243,830.6 мян төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. | буюу 99.31 хувийн биелэлттэй зарцуулсан. | |
| 2.1.10. | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардлын төлөвлөгөө 1,591.7 сая төгрөг байсан ба зардлын ангилалын дагуу 25.0 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан. | а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх.<br>б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах<br>в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | 2025 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардалд 1,722.7 мянган төгрөг зарцуулахаас 1,602.5 мянган төгрөгийг зарцуулж 120.2 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна. | |
| 2.1.11. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон | Хуульд заасан цаглабарын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Аймгийн холбогдох байгууллагуудад санхүүгийн 12 удаагийн мэдээ, 4 удаа тайланг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | | тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | | |
| 2.1.12. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах;<br>-Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд | 2025 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 06 сарын 14-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/92 тушаалыг үндэслэн тус газрын Өмч хамгаалах байнгын зөвлөл нь үндсэн хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийж тайлан, мэдээ, судалгааг холбогдох газруудад хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.<br>- Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” програмд оруулж ажилласан.<br>- Хагас жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг гаргаж хүргүүлсэн.<br>- Газрын даргын 2025.01.25 өдрийн А/3 дугаар тушаалаар тооллогын комисс томилогдон ажиллаж 2025 оны төлөвлөгөө батлуулан, өмч хөрөнгийн тооллого хийж дүгнэлт гарган даргын зөвлөлийн хурлад танилцуулсан.<br>- Ашиглалтын хугацаа дуусаж,эвдэрч гэмтсэн үндсэн хөрөнгийн судалгаатай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээлэх;<br>-Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх;<br>--Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, | гаргаж, актлах,хугацааг сунгах 22 нэр төрлийн 72 ширхэг 23,941,588 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө жагсаалтыг дээд газарт хүргүүлсэн. | |
| 2.1.13. | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах. | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | а)Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан.<br>б)Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна. | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажилласан. | |
| 2.1.1 | Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан | | Нийгмийн даатгалын ерөнхий | Банкуудтай байгуулсан гэрээний | а)Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкнуудтай байгуулсан 2024 оны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх. | | газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ. | биелэлтийг дүгнэж НДЕГ-т хүргүүлсэн. Хаанбанк – 99.38 хувь, Төрийн банк – 99.75 хувь, Голомт банк – 99.75 хувь, ХХБанк – 99.33 хувь, Капитрон банк – 99.33 хувь | хэрэгжилтийг хангаж ажиллах.<br>б)Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | гэрээг 2025.01.10-ны өдөр зүйл заалт бүрээр дүгнэж, биелэлтийг НДЕГ-т хүргүүлж ажилласан.<br>2025 онд хамтран ажиллах гэрээг 02 дугаар сард байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилтийг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор дүгнэж НДЕГ-т хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| 2.1.15. | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | а)Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б)Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | Нийгмийн даатгалын системийн цахим мэдээллийн сан илүү ухаалаг түвшинд шилжиж байгаатай холбоотойгоор шинэ болон хуучин программ хангамжуудыг давхар ашиглаж алдаа, залруулга гаргахгүйгээр ажиллаж байна.<br>Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргалгүй ажилласан. | |
| 2.1.16. | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. Тус газраас 2024 онд системийн 12 алдааг илрүүлж засварлуулсан. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | Шинэ системийн шинэчлэлт, сайжруулалттай холбоотой тулгамдсан асуудлуудыг Нийгмийн даатгалын газарт цаг тухай бүрд уламжлан Ай Ти Зон ХХК-ны программистуудаар алдааг засварлуулан ажиллаж байна. Тус газраас системийн 2025 онд 8 алдааг илрүүлж засварлуулсан.<br>Системийн сайжруулах ажил хийгдэж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | “Core” системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | | | | |
| 2.1.17. | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан. | а)Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах.<br>б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | Нийгмийн даатгалын сангийн харилцах дансны үлдэгдлийг арилжааны банкнуудтай тооцоо нийлэн баталгаажуулж, сангийн бусад өглөг, авлагыг холбогдогч, байцаагч ажилтнуудаар улирал бүр гарын үсэг зуруулан баталгаажуулсан. | |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх *(Алсын хараа-2025 3.1.5, 5.6.3, ЗГҮАХ-2.1.3.7, 4.1.4.1, 4.2.2.5, АЗДҮАХ-4.2.1.1)* | | | | | | | |
| 3.1.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2024 оны байдлаар 99.5 хувьтай байршуулсан. | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна. | Байгууллагын 48 мэдээллийг веб хуудас,<br>Байгууллагын 48 мэдээллийг веб хуудас, фэйсбүүк хаяг, мэдээллийн 6 самбарт байршуулж улирал бүр дүгнүүлэн ажиллаж байна. Үнэлгээ авсан байдал:<br>1-р улирлын үнэлгээгээр 96% үнэлүүлсэн.<br>2-р улирлын үнэлгээгээр 99% үнэлүүлсэн.<br>3-р улирлын үнэлгээгээр 99% үнэлүүлсэн.<br>4-р улирлын үнэлгээ хүлээгдэж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг хүргүүлнэ. | | | | |
| 3.1.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийгмийн даатгалын байгууллагын сангийн болон, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд хүргүүлнэ. Хэрэгжилтийн хувь | Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн 91, сангийн 64 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангаан ажилласан бөгөөд 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 155 мэдээллийг байршуулсан байна. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны 171 мэдээлэл байршуулахаас хуулийн хугацаанд бүрэн 149 мэдээлэл байршуулж, 1 мэдээлэл хоцорч байршуулсан.<br>Нийгмийн даатгалын сангийн 159 мэдээлэл байршуулахаас хуулийн хугацаанд бүрэн 141 мэдээллийг байршуулсан.<br>нийт 290 мэдээллийг байршуулж, хугацаандаа 99,6% байршуулан хэрэгжүүлэн ажилласан байна. | |
| Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах | | | | | | | |
| 3.2.1. | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, | Шаард-лагагүй | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилти | 2024 онд Дотооддоо 8, гадагшаа 3 чиглэлээр нийт 11 шалгалт хийж, | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр | Дотооддоо 8 чиглэлээр хяналт шалгалт хийж 4 зөвлөмж, 2 албан шаардлага, 79.00 сая төгрөгийн зөрчилд 2 улсын байцаагчийн акт үйлдэж 57.9 сая төгрөгийг барагдуулсан.<br>- Ажилгүйдлийн сан<br>- Нийтийн ил тод мэдээллийн байдлын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | | йг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | шалгалтын илэрсэн 73.9 сая төгрөгийн төлбөрийн зөрчлөөс 49,7 сая төгрөгийг буюу 67,25% барагдуулж ажилласан. | гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | тухай хуулийн хэрэгжилт<br>- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт<br>- Байгууллагын үйл ажиллагааны зардал<br>- Нийгмийн даатгалын сан<br>- Жаргалант сумын үйл ажиллагаа<br>- Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа<br>- 2024-2025 оны Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хийсэн залруулга, нөхөн тайлагнасан үйл ажиллагаа<br>Гадагшаа 3 чиглэлээр хяналт шалгалт хийж 28.54 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн ажиллаж 100% барагдуулсан.<br>- Нийгмийн хамгааллын салбарын хяналт<br>- Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдэд төлөвлөгөөт хяналт шалгалт<br>- Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгах<br>Нийт 107.54 сая төгрөгийн төлбөрийн зөрчлөөс 86.44 сая төгрөгийг буюу 80,37% барагдуулж ажилласан. | |
| 3.2.2. | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэж дүгнэх, | Шаард-лагагүй | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүнг хагас, бүтэн жилээр нэгтгэж дүгнэсэн байдал | ЗХ-ны 186-р ангид алба хааж байсан 3 албан хаагчтай холбоотой нийт 116.5 мянган төгрөгийн шимтгэл алдангийг нөхөн төлүүлж шийдвэрлэсэн. | Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажилласан байна. | ЗХ-ний 186-р ангид 1995-1997 оны хооронд хугацаат цэргийн алба хааж байсан 3 албан хаагчийн өргөдлийн дагуу нийт 116.4 мянган төгрөгийн шимтгэл алдангийг нөхөн төлүүлж, цахим мэдээллийн санд шимтгэл төлөлтийн мэдээллийг оруулж бүрэн шийдвэрлэсэн. | |
| 3.2.3 | Нийгмийн даатгалын сангуудын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх | | Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт | 2024 онд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн 2,5 сая | Нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг | ГБХНХЯ-аас 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн баталсан 13-07/06 дугаартай удирдамжийн дагуу Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны зарцуулалтыг шалгах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| . | | | ад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож үр дүнд хяналт тавьж ажиллах, Зөрчил барагдуулсан хувь, | төгрөгийн төлбөрийн зөрчлийг 100 хувь барагдуулж ажилласан. | мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан шалгаж, илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах | ажлын хүрээнд 2762 ажилгүйдлийн хувийн хэргийн бодолт, олголтыг шалгахад 52.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн акт үйлдэж 21.6 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 18 даатгуулагчид нөхөн олгож, 30.3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 28 даатгуулагчид илүү олгосноос 11.3 сая төгрөгийг барагдуулж зөрчлийг арилгах арга хэмжээ авч дөрөвдүгээр улирлын байдлаар 32.9 сая төгрөгийг барагдуулсан нь 63.27%-ийн биелэлттэй байна. | |
| 3.2.4. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх | | Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор , гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | Төлөвлөгөөнд тусгасан 15 байгууллагаас 15 ажил олгогчид төлөвлөгөөт шалгалт хийж, шалгалтын явцад 2 байгууллага дээр зөрчлийн хэрэг нээж 2000 нэгжээр торгох шийтгэл оногдуулж, 4 даатгуулагчийн 1.6 сая төгрөгийн хохирол нөхөн төлбөрийг 100% төлүүлэн буруу тайлагнасан, даатгуулагч орхигдуулсан зөрчлийн нөхөн залруулан ажилласан. | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, ирэлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Төлөвлөгөөт тусгасан 15 байгууллагаас хуваарийн дагуу 14 объектод хяналт шалгалт хийж, 3 албан шаардлага өгч, 1 байгууллагад зөрчлийн тухай хуулийн дагуу 5.0 сая төгрөгийн торгууль оногдуулан 100% барагдуулж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.5 | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх, | | Дотоодын хяналт, шалгалтыг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу хэрэгжүүлсэн байдал<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь,. | 2024 онд Дотоод хяналт шалгалтаар 18 улсын байцаагчийн акт үйлдэж 8.7 сая төгрөгийн төлбөрийг бүрэн барагдуулан, зөрчлийн 44 хэргийг бүртгэл авч 41.6 сая төгрөгийн төлбөр, 9.5 сая төгрөгийн торгуулийг 100% барагдуулан ажилласан. Өмнөх оны 10.3 сая төгрөгийн авлагыг 38,8% бууруулан 6.3 сая төгрөг болгон ажилласан. | Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулан гаргасан.<br>- Дотооддоо 7 чиглэлээр хяналт шалгалт хийж 3 зөвлөмж, 2 албан шаардлага, 79.00 сая төгрөгийн зөрчилд 2 улсын байцаагчийн акт үйлдэж 57.9 сая төгрөгийг буюу 73,29% барагдуулсан.<br>- НДЕГ-ын тэтгэврийн даатгалын санд хяналт шалгалтаар илэрсэн төлбөр 2.59 сая төгрөгийн актаас 0.51 сая төгрөгийг буюу 19,69% барагдуулсан.<br>- 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас 34.14 сая төгрөгийн зөрчлийг давтан гарахгүй байх албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажиллах 4 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг газрын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 100% хангаж ажиллаж, тайланг хүргүүлсэн. | |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах<br>*(Алсын хараа-2050 5.4.9-5.4.11, 5.4.15-5.4.17, ЗГҮАХ-2.1.3.2, 2.1.3.7, 4.2.1.1, 2.3.2.3 АЗДҮАХ-2.5.1.1, 4.1.1.6, 4.3.1.1, 4.3.1.5, Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл-5.1.2, 5.1.3, 5.1.5)* | | | | | | | |
| 4.1.1. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд | | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын | 2024 оны жилийн эцсийн байдлаар НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой<br>**МУЗГ-ын тогтоол:**<br>- 2025.01.02-ны өдрийн “Эрүүл мэндийн магадлалын хувь хэмжээ тогтоох тухай” 02 дугаар тогтоол<br>- 2023.11.29-ны өдрийн Журам батлах тухай Дугаар 422 тогтоол<br>- 2024.11.13 Төрийн байгууллагын үйл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | | тогтоол, шийдвэр, НДЕГ-ийн даргын тушаал шийдвэр үүрэг даалгаварын хэрэгжилт хангагдсан байна. хэрэгжилтийн хувь | жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд хэрэгжилт 93,5%-тай хэрэгжсэн байна | | ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай №163 тогтоол<br>- 2025.08.20 Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №52 тогтоол<br>**Албан даалгавар:**<br>- МУ-ын Ерөнхий сайдын 2025.03.06-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгавар<br>- Мөн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан 2025 оны эхний хагаст орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 03 дугаар албан даалгавар<br>- МУ-ын Ерөнхий сайдын “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах бүтээмжийг сайжруулах тухай” 2025.06.18 №01<br>- ГБХНХЯ-ны сайдын 2025.02.25-ны өдрийн “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлэн ажиллах тухай” 03 дугаар албан даалгавар<br>**Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоол:**<br>- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 02 дугаар тогтоол<br>- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025.02.07-ны өдрийн ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 06 дугаар тогтоол<br>- Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025.07.23-ны өдрийн 10 дугаар тогтоол<br>- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 07 дугаар тогтоол<br>- Сэргээн засах болон сувиллын тусламж үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай 2025.07.23 №12<br>**НДЕГ-ын даргын албан даалгавар**<br>- Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны “Ажлын хариуцлага, сахилга дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай” 01 албан даалгавар<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын цахим уулзалтаар аймаг дүүргийн нийгмийн даатгалын газрын дарга нарт өгсөн үүрэг даалгавар гэх мэт Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол шийдвэр, албан даалгавруудыг хэрэгжүүлэн ажиллаж тайлан мэдээг хагас бүтэн жилээр тайлагнан ажиллаж байна.<br>Мөн 2025 оныг “Нийгмийн даатгалын өр, авлага барагдуулах жил” болгон зарласантай холбогдуулан Нэрэмжит жилийн төлөвлөгөөг 3 зорилт 28 арга хэмжээтэйгээр төлөвлөн ажиллаж биелэлтийн сар бүр хүргүүлэн ажилласан. | |
| 4.1.2. | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2024 онд 90,1 %-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор аймгийн ЗДТГ | Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас 2025 оны 12 дугаар сарын байдлаар нийт 317 өргөдөл, 0 санал ирснээс хуулийн хугацаа болсон 297 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг хуулийн хугацаанд өгч ажилласан. 20 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.<br>Өргөдөл хүсэлтийн мэдээг сар бүр буюу нийт 12 удаа, тайланг 4 удаа гаргаж холбогдох газарт хүргүүлсэн.<br>Шийдвэрлээгүй буюу, хугацаа хоцроож | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хуулийн хугацаанд тайлагнасан байна. | | болон НДЕГ-т хүргүүлнэ. | шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо 0 байна. Шийдвэрлэлтийн хувь 90% | |
| 4.1.3. | Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх. | | Нийгмийн даатгалын газрын дотооддоо болон хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна. Лавлагааны тоо | 2024 оны байдлаар бусад аймаг дүүрэг рүү 401 лавлагаа захиалан авсан, бусад аймаг, дүүргээс 174 лавлагаа ирсэн. Нийтдээ 475 лавлагааг аймаг, дүүргийн хэлтсүүдтэй цахимаар солилцож нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй хөнгөн шуурхай хүргэж ажилласан. | Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна. Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлж ажиллана. | 2025 оны жилийн эцсийн байдлаар бусад аймаг дүүрэг рүү 339 лавлагааны хүсэлт цахимаар илгээж, лавлагааны хариуг хуулийн хугацаанд иргэдэд олгож даатгуулагчдын цаг хугацаа, зардлыг хэмнэж ажилласан.<br>Мөн бусад аймаг дүүргээс ирсэн 168 лавлагаа авах хүсэлтийг шийдвэрлэж, иргэд, даатгуулагчдад түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлсэн.<br>2025 оны жилийн эцсийн байдлаар тус газраас нийт 507 лавлагааг үнэн зөв гаргаж<br>Иргэд даатгуулагчдад олгосон байна. | |
| 4.1.4. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах. | | Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргасан байх, | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлж, орон тооны болон төсвийн хэтрэлтгүй ажилласан. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т, Аймгийн Тамгын газарт улирал бүр тайлагнасан байна. | 2025 оны 12 дугаар сарын байдлаар орон тооны болон цалингийн сангийн хэтрэлтгүй ажилласан.<br>Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны А/239 дүгээр тушаалаар тус газрын орон тоог 36-аар баталсан бөгөөд гүйцэтгэлээр 35 албан хаагч ажиллаж байна.<br>2025 оны эхний хагаст 2 сул орон тоо гарсан. Нэг цэгийн үйлчилгээний байцаагчийн орон тоог Төрийн албаны тухай хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулж төрийн албаны нөөцөөс нөхсөн бол, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний орон тоог төрийн өөр байгууллагаас шилжүүлэн авч ажиллуулах журмын дагуу нөхсөн.<br>Орон тооны гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 05-ны өдрийн дотор дээд шатны байгууллагад | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайлагнан ажиллаж, хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж ажилласан. | |
| 4.1.5. | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх | | Шинэлэг ажлын тоо, хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүн | 2024 онд байгууллагын үйл ажиллагаа бүтээмжийг дээшлүүлэх 8 төрлийн шинэ ажил зохион байгуулж хэрэгжүүлсэн. | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ, Аймгийн Тамгын газарт хүргүүлнэ. | Шинэлэг ажлын хүрээнд хамт олны стресийн түвшинг бууруулах, бүтээмжийг ил тод нээлттэй үнэлэх, нийгмийн даатгалын багц хуулийн мэдлэгийн бататгах 3 арга хэмжээг зохион байгуулан ажилласан, Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх 2 ажил шинээр хэрэгжүүлж байна.<br>1. Нийт албан хаагчдаас байгууллагын дотоод ажлыг сайжруулах зорилгоор Казейн санал авахад 9 санал ирсэн бөгөөд шилдэг 2 санлыг шалгаруулан хэрэгжүүлэн байна.<br>- “Стрессгүй хамт олон” төсөл арга хэмжээ<br>- “Бүтээмжийн үнэлгээний самбар”<br>2. 2025 оны 05 дугаар сард 5С аян зохион байгуулж 43 албан хаагчдаас 16 албан хаагч амжилттай оролцож “Эмх цэгцтэй ажилтан” үнэлгээ авсан байна.<br>3. Албан хаагчдыг идэвхжүүлэх зорилгоор улирал бүр 2 тэмцээн зохион байгуулсан.<br>- Сийрэг толгой<br>- Гавал толгой тэмцээн зохион байгуулж албан хаагчдын хуулийн мэдлэгийг дээшлүүлж ажилласан.<br><br>4. 2025 онд Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас санхүүгийн дэмжлэг авч буй иргэдийг сайн дурын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд 21 даатгуулагчийг хамруулсан ба эдгээр даатгуулагчид санхүүгийн дэмжлэгийн гэрээнд зааснаар 3 жилийн хугацаанд сайн дурын даатгалд хамрагдах юм.<br>5. Нийгмийн даатгалд хамрагдсан шинэ аж ахуй нэгж байгууллагад тухай бүр сургалт орж мэдээлэл зөвлөгөө хүргэж хэвшсэн.<br>2025 оны байдлаар шинэ 62, үйл ажиллагаа нь жигдэрсэн 169-н байгууллагын захирал, нягтлан бодогч нарт мэдээ зөвлөгөө хүргэж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 4.1.6. | Газрын ажилтан албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах | | Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | 2025.06.03-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалтын талаарх сургалтад 38 албан хаагч оролцож Авлигын эсрэг хуулийн мэдлэгээ сайжруулсан.<br>Авлигатай тэмцэх газрын даргын 2024 оны "Заавар батлах тухай" А/96 дугаар тушаал шинээр батлагдан гарч, хэрэгжүүлэн ажиллахтай холбогдуулан ХАСХОМ гаргах 17 албан хаагчид Захираа, хяналтын тасгийн дарга Г.Галбадрах сургалт орж, мэдээлэл хүргэсэн.<br>Мөн тус газрын Авлигын эсрэг стандартын комисс 2025 онд 3 зорилт 19 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан 2 удаагийн сургалтад нийт 41 албан хаагчийг хамруулсан. Авлига, гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хагас жилийн дэлгэрэнгүй тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br><br>2025.10.14-ний өдөр Аймгийн ЗДТГ Хууль, эрх зүйн хэлтсийн эрх зүйн хөтөч Г.Ганчимэгийн "Төрийн албан хаагчийн ёс зүй, авлигаас ангид байх" сэдвээр сургалт авч нийт 39 албан хаагчийг хамруулсан байна.<br>2025 онд тус газрын ажилтан албан хаагчид авлига, ашиг сонирхол, гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргаагүй ажилласан. | |
| 4.1.7. | Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг | | НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн | Нийгмийн даатгалын хэлтсийн даргын | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа | НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хanган ажиллах | | даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн “Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт” батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөж ажилласан байна | 2023 оны А/36 тоот тушаалаар баталсан “Байцаагч ажилтны ажлын байран дээр тавигдах үйлчилгээний стандарт”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, байгууллагын стандартын дотоод хяналтын баг тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2024 онд дээрхи стандарттай холбоотой үл тохирол бүртгэгдээгүй байна. | хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажилласан байна. | “Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт” батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөж ажилласан байна. Мөн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2023 оны А/36 тоот тушаалаар баталсан “Байцаагч ажилтны ажлын байран дээр тавигдах үйлчилгээний стандарт”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, байгууллагын стандартын дотоод хяналтын баг тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2025 онд дээрх стандарттай холбоотой үл тохирол бүртгэгдээгүй байна. Үйлчилгээний А хэсгийн байцаагч ажилтнуудтай холбоотой гомдол санал гараагүй. | |
| Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
